

# Мөнхийн ач холбогдолтой сонголтууд, 2-р хэсэг



Хоёрдугаарт: Тэнгэрлэг Эцэг, Түүний Хүү хоёрын та нарт санал болгосон үнэнийг мэдэж ав.

Товчхондоо, Тэд та нарт бүхнийг санал болгосон.

Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүддээ зориулсан авралын төлөвлөгөө нь бидэнд Түүний амьдарч буй газарт Түүнтэй адил амьдарч, эцэстээ Түүнтэй илүү адилхан болох боломжийг олгоно. “Христийн хамтран залгамжлагчид” [Ром 8:17] болох бидэнд байгаа чадавх зэрэг хамгийн баялаг мөнхийн адислалуудыг Түүний төлөвлөгөө бидэнд боломжтой болгодог.

Бурхан бүхнийг мэддэг, бүхнийг хардаг. Хэн ч хэзээ ч та нарыг Түүн шиг мэддэггүй эсвэл та нарт анхаарал тавьдаггүй. Хэн ч хэзээ ч та нарт Түүн шиг ойр байдаггүй. Тэр та нар луу Ариун Сүнсийг болон тэнгэр элч нараа илгээн, та нарыг харж хандаж болохын тулд, Түүнд зүрх сэтгэлээ уудалж мөн итгэж найдаж болно. Тэр цорын Ганц Хүүгээ та нарын Аврагч, Гэтэлгэгч байлгахаар илгээж, үхүүлэхээр илгээхдээ Өөрийн бүхий л хайрыг харуулсан юм.

Их Эзэн Есүс Христ Цагаатгалаараа дамжуулан дэлхийг ялсан [Иохан 16:33; Сургаал ба Гэрээ 50:41-ийг үзнэ үү]. Тиймийн тул, Тэр “[чамайг] зөв шударга бус бүхнээс цэвэрлэж мөн аврах чадалтай” [Алма 7:14]. Тэр та нарыг хамгийн хүнд нөхцөл байдлуудаас чинь Өөрийн арга замаар, Өөрийн цаг хугацаанд гаргах болно. Та нарыг Түүнд итгэлтэйгээр ирэх үед Тэр та нарыг чиглүүлж, харж хандаж, хамгаалах болно. Тэр та нарын шархалсан зүрх сэтгэлийг эдгээж, хэцүү үед чинь тайтгаруулах болно [Лук 4:18; Алма 7:10–12-ыг үзнэ үү]. Тэрээр та нарт Өөрийн хүчийг ашиглах эрхийг өгөх болно. Мөн Тэр та нарын амьдрал дахь боломжгүй зүйлсийг боломжтой болгох болно. . . .

Бурхан баптисмын усанд Өөртэй нь гэрээ байгуулах хүн бүрийг онцгойлон хайрладаг. Тэрхүү тэнгэрлэг хайр нь гэрээнүүд нэмж байгуулан, итгэлтэйгээр сахисан үед гүнзгийрдэг. Тэгээд мөнх бус амьдралын төгсгөлд гэрээ байгуулсан хүүхэд бүр Тэнгэрлэг Эцэгтэйгээ дахин нэгдэх нь эрхэм нандин үнэ цэнтэй байх болно [Дуулал 116:15-ыг үзнэ үү].

Мөн Тэр Өөрийнх нь бүх хүүхэд сэргээгдсэн сайн мэдээний баярт захиасыг сонсох боломжтой байгаа эсэхэд *онцгойлон* анхаардаг. Тэнгэрлэг Эцэг хүүхдүүдээ энэ дэлхий рүү зургаан мянга гаруй жилийн турш илгээсэн. Энэ хүмүүсийн ихэнх нь өөрсдийг нь мөнх амьдралд хүргэх ёслолуудыг хараахан хүлээн аваагүй байна. Чухам иймээс л ариун сүмүүд чухал ач холбогдолтой байдаг. Хөшигний хоёр талд Израилыг цуглуулах нь өнөөдөр дэлхий дээрх *хамгийн* чухал ажил болоод байна. Энэ ариун ажил дахь хамтран зүтгэгчид минь, та нарыг энэ цуглуулах ажилд нэн чухал үүрэг гүйцэтгэж байгаад би талархаж байна. (Рассэлл М.Нэлсон, “Мөнхийн ач холбогдолтой сонголтууд” [Залуучуудад зориулсан дэлхий даяарх онцгой цугларалт, 2022 оны 5-р сарын 15], broadcasts.ChurchofJesusChrist.org)